



НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

Төлбөртэй тусламж үйлчилгээний журам,
жагсаалтыг шинэчлэн батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэхь заалт, Эрүүл мэндийн сайдын “Худалдаа үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах журам батлах тухай” 2017 оны 04 сарын 14-ний өдрийн А/145 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2022 оны “Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” 49/А/118, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Жагсаалт, журам батлах тухай” А/216, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан Гадаад ажилтныг Монгол Улсад ирсний дараа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах журам батлах тухай А/483, А/220 дугаар тушаал, 2023 оны Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01, 02 дугаар тогтоол, 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь

1.Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвөөс иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр нэмэлтээр үзүүлж буй тусламж үйлчилгээ болон эрүүл мэндийн даатгалгүй иргэдэд үзүүлэх “Төлбөртэй тусламж, үйлчилгээний журам”-ыг нэгдүгээр, “Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, төлбөрийн хэмжээ”-г хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Журмын дагуу төлбөртэй тусламж үйлчилгээг чанар, хүртээмжтэй зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Амбулаторийн эрхлэгч (Т.Ундрах), Салбар амбулатори, Сэргээн засах төвийн эрхлэгч нарт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, зохион байгуулалтад хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан орлогч дарга (Э.Сарантуяа)-д тус тус үүрэг болгосугай.

3.Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт ил тод байршуулан иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудыг мэдээллээр хангах, үйлчлүүлэгчийг албан бус төлбөр төлөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг Бодлого, төлөвлөлт хариуцсан орлогч дарга (Б.Баярмаа)-д хариуцуулсугай.

4.Төлбөртэй тусламж үйлчилгээнээс олсон орлогыг хууль тогтоомжид нийцүүлж төвлөрүүлэн, зориулалтын дагуу зарцуулж, улирал тутам Эрүүл мэндийн төвийн удирдлагын зөвлөлд тайлагнахыг Эдийн засаг, санхүү хөрөнгө оруулалтын албаны дарга (Б. Батнасан)-д даалгасугай.

5.Төлбөртэй тусламж үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлого, зарлагын гүйцэтгэл, төлбөрт үйлчилгээний хэрэгжилтийн байдалд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, үнэлгээний мэргэжилтэнд үүрэг болгосугай.

6.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн “Төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт журам, жагсаалт батлах тухай” А/86 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА



М.ОДГЭРЭЛ

Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төвийн
даргын 2024 оны 14 дугаар сарын 18 өдрийн
14/28 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

9023110481 9086663 НД2335

ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол улсын үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжид заасныг үндэслэн Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвөөс иргэн, **хуулийн этгээдэд** тусламж үйлчилгээг төлбөртэй үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заагдсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хувь хүн, байгууллага хамт олны хамрагдах хүсэлтийн дагуу болон гэрээнд үндэслэн төлбөрийг байгууллагын төрийн сан банкны 100200620001 дугаар бүхий Эрүүл мэндийн төвийн данс болон кассын няравт 100 хувь тушааж баталгаажсан баримт гаргуулснаар үзлэг, шинжилгээг эхлүүлж үйлчлүүлнэ.

Хоёр. Төлбөртэй тусламж, үйлчилгээнээс олсон орлогыг зарцуулах, төвлөрүүлэх, төсөвт тусгах

2.1. Нэмэлт болон төлбөртэй тусламж үйлчилгээний орлогыг өмнөх жилийн орлогоос имфляцийн түвшинтэй уялдуулан бодитой төлөвлөж жилийн төсөвт тусгана.

2.2. Нэмэлт болон төлбөртэй тусламж үйлчилгээнээс олсон орлого нь байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогод бүртгэгдэнэ.

2.3. Төлбөртэй үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт болон төлбөрийн хэмжээг үйлчлүүлэгчид ил газар байрлуулж, лавлагааг цахим бүртгэлийн бүртгэгч болон лавлагааны ажилтан хариуцаж ажиллана.

2.4. Төлбөртэй тусламж үйлчилгээний орлогыг байгууллагын төрийн сан дахь төсвийн харилцах данс болон мөнгөн кассаар дамжуулан хүлээн авна. Байгууллагын мөнгөн кассаар хүлээн авсан орлогыг мөнгөн кассын нярав өөрийн биеэр тухайн өдөртөө багтаан төрийн сан дахь харилцах дансанд тушаана.

2.5. Иргэнд төлбөр төлсөн баримтыг заавал олгох бөгөөд уг баримтад байгууллагын нэр, иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний нэр, төлбөл зохих нийт дүн болон үйлчилгээ нэг бүрийн төлбөрийн хэмжээ үүнээс эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээ, хувь хүний төлсөн хувь хэмжээ, тусламж үзүүлсэн эмчийн нэр огноог тэмдэглэсэн байна.

2.6. Гадаадын иргэд үзлэг, оношилгоо, эмчилгээ хийлгэх тохиолдолд хоёрдугаар хавсралтын дагуу төлбөрийг 100 хувь төлнө.

2.7. Төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлсэнээс бий болох орлогын 50 хүртэл хувийг эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл (код 210501) эдийн засгийн ангилалд, орлогын 30 хүртэл хувийг эд хогшил, урсгал засварын зардал (код 2106) эдийн засгийн ангилалд, орлогын 20 хүртэл хувийг урамшуулалд (код 210104), ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл (код 2102) ангилалд тус тус төсөвлөнө.

Гурав. Төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох

3.1. Төлбөртэй үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоохдоо Монгол Улсын хууль болон Засгийн газрын гишүүдийн баталсан тушаал, ЭМДҮЗ-ийн тогтоолыг тус тус үндэслэн байгууллагын тусламж үйлчилгээний бодит өртөг, зардлыг тооцон төлбөрт үйлчилгээний нэр төрөл, хэмжих нэгж, төлбөрийн хэмжээг Эрүүл мэндийн

төвийн даргын тушаалаар батлана. Төлбөрийн хэмжээг нэмэх, хасах өөрчлөлт орсон үед мөн даргын тушаалаар дахин баталгаажуулна.

3.2.Төлбөртэй тусламж, үйлчилгээний журмын төслийг удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн эцэслэнэ.

3.3.Төлбөртэй тусламж үйлчилгээний журмын хоёрдугаар хавсралтын Эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг зөвлөгөөний дагуу аж ахуйн нэгжтэй гэрээ хийхдээ 120 хүнээс дээш хүнтэй байгууллагад хөнгөлөлт үзүүлж болно.

3.4.Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар батлагдсан журам болоод төлбөрийн хэмжээг шилэн дансны мэдээлэлд тухай бүр оруулна.

Дөрөв. Хориглох зүйл.

4.1.Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24. тусгагдсан тусламж үйлчилгээ буюу "Төлбөрийг нь төрийнг үйлчилгээ"-г авч буй иргэнээс төлбөр авах.

4.2.ЭМД-ын сангаас оношилгоо, шинжилгээнд олгож буй зардлыг даатгуулагчаас давхардуулан авах.

4.3.Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилтан аливаа төлбөрт үйлчилгээний тооцоог үйлчлүүлэгчээс шууд хүлээн авахыг хатуу хориглоно.

4.4.Эмч, эмнэлгийн ажилчид Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ оношлогоо, нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлснээрээ ажлын байранд эм, биобэлдмэл, биологийн идэвхит бодис, ахуйн хэрэгсэл худалдаалахыг хатуу хориглоно.

4.5.Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь иргэдээс жагсаалтад зааснаас бусад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон анхан шатны маягт, бие засах газар, нөмрөг, улавч, машины зогсоол, халадны үнэ, өвчтөн шилжүүлэх болон шинжилгээний бичиг олгох, хувцас өлгөх зэрэг нийтлэг үйлчилгээнээс төлбөр авахгүй.

Тав. Хяналт, үнэлгээ

5.1.Энэхүү орлогын баталгаажуулалтыг сар бүр эдийн засаг санхүү хөрөнгө оруулалтын албаны дарга, ахлах нягтлан бодогч хянаж улирал бүр удирдлагын зөвлөлийн хуралд танилцууна.

5.2.Эмнэлгийн дотоод журмыг зөрчсөн эмчлүүлэгчдэд төлбөрийг буцаан олгохгүй.

5.3.Төлбөрт тусламж үйлчилгээ нь байгууллагын үндсэн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй, эмнэлгийн тусламж үйлчилгээ хэвийн ажиллуулахыг эмчилгээ эрхэлсэн орлогч дарга хариуцна.

5.4.Төлбөрт тусламж үйлчилгээний орлого, бүрдүүлэлтэд санхүүгийн хяналтыг улирал бүр, байгууллагын дотоод хяналтын үнэлгээг жилд 2 удаа хийнэ.

Зургаа. Журам зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага

6.1.Иргэнээс энэхүү журамд зааснаас бусад төлбөр авсан, мөн төлбөрийн хэмжээг дээд хязгаараас хэтрүүлэн тогтоож иргэнээс илүү төлбөр авсныг мэргэжлийн хяналтын байгууллага болон эрх бүхий хуулийн этгээд нотолсон тохиолдолд үйлчлүүлэгчийн хохиролыг хохирол учруулсан этгээд хариуцах, хөдөлмөрийн гэрээг цуцлах хүртэл арга хэмжээг авна.

6.2.Хэрэв эрүүл мэндийн төвийн дарга эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлага хүлээлгэх боломжгүй тохиолдолд зөрчил гаргасан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны асуудлыг холбогдох байгууллагад шалгуулахаар шилжүүлнэ.

Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төвийн
даргын 2024 оны 04 дугаар сарын 02 өдрийн
1/28 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ,
ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

№	Тусламж үйлчилгээний нэр төрөл	Код	Тусламж үйлчилгээний үнэ
1. ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ			
Клиник биохими			
1.1	АЛАТ	10102003	3,000
1.2	АСАТ	10102010	3,000
1.3	Нийт билирубин	10102013	3,000
1.4	Шууд билирубин	10102014	3,000
1.5	Нийт билирубин	10102057	3,000
1.6	Альбумин	10102004	3,000
1.7	Шүлтлэг фосфотаза	10102086	4,000
1.8	Гаммаглутамилтрансфераза	10102018	3,000
1.9	Амилаза	10102006	5,000
1.10	Нийт холестерин	10102081	3,000
1.11	Триглицерид	10102072	4,000
1.12	Креатинин	10102033	4,000
1.13	Мочевин	10102052	4,000
1.14	Шээсний хүчил	10102091	3,000
1.15	Лактатдегидрогеназа	10102043	4,000
1.16	Глюкоз	10102021	3,000
1.17	Их нягтралтай липопротеин /ИНЛП/	10102027	6,000
1.18	Бага нягтралтай липопротеин /ИНЛП/	10102011	10,000
1.19	Глюкожсон гемоглобин-HbA1c	10106112	17,000
Иммунологийн шинжилгээ			
1.20	HbsAg түргэвчилсэн тест	10106204	6,000
1.21	Anti HCV түргэвчилсэн тест	10106206	6,000
1.22	ДОХ түргэвчилсэн тест	10106116	6,000
1.23	Сүрьеэгийн Anti-TB cassette	10106014	9,000
1.24	RPR	10106014	8,000
1.25	Тэмбүү илрүүлэх өвөрмөц сорил (TPHA)	10106172	5,000
1.26	Ковид 19 илрүүлэх түргэвчилсэн тест		15,000
1.27	Элэгний хавдрын маркер (AFP)	10106230	20,000
1.28	Өндгөвчний хавдрын маркер CA 125 II	10106141	25,000
1.29	Түүрүү булчирхайн хавдрын маркер (PSA)	10106169	21,000
1.30	Нойр булчирхайн хавдрын маркер (CA 19-9)	10106207	30,000
1.31	Ходоодны хавдрын маркер (CA 72-4)	10106208	35,000
1.32	Хөхний хавдрын маркер (CA 15-3)	10106209	35,000
1.33	Бүдүүн гэдэсний CEA	10106098	22,000
1.34	Тиреод сэдээгч даавар (TSH)	10106158	17,000
1.35	Тироксин даавар (T4)	10106161	17,000
1.36	Триодтиронин даавар (T3)	10106164	15,000

1.37	Тироглобулины (TG)	10106159	19,000
1.38	Паратиреоидын даавар (PTH)	10106148	35,000
1.39	Прогестерон	10106149	23,000
1.40	Пролактин	10106151	23,000
1.41	Тестостерон	10106156	24,000
1.42	Фолликул сэдээгч даавар (FSH)	10106187	18,000
1.43	Хүний хорион гонадотропины даавар (HCG+b II)	10106211	22,000
1.44	Шар биеийг идэвхжүүлэгч даавар (LH)	10106220	20,000
1.45	АСЛО латекс (чанарын аргаар)	199011001	5,000
1.46	СРП латекс (чанарын аргаар)	199011001	5,000
1.47	РФ латекс (чанарын аргаар)	199011001	5,000
Коагулограмм			
1.48	PT-Протромбины хугацаа (INR)	10109019	5,000
1.49	APTT- Зориуд идэвхжүүлсэн тромбопластины хугацаа	10109001	5,000
1.50	FIB- Фибриногены хэмжээ	10109005	6,000
1.51	TT- Тромбины хугацаа	10109012	5,000
Витамин болон эрдэсийн шинжилгээ			
1.52	Са- Кальци	10102030	4,000
1.53	К-Кали	10102028	5,000
1.54	Na-Натри	10102055	5,000
1.55	P-Фосфор	10102075	3,000
1.56	Mg-Магни	10102048	4,000
1.57	Cl- Хлор	10102079	5,000
1.58	Fe-Төмөр	10102070	4,000
1.59	Витамин Д	10106107	40,000
1.60	Ферритин (Ferritin)	10106185	26,000
Гематологи			
1.61	Цусны ерөнхий шинжилгээ /20 үзүүлэлтээр/	10104008	14,000
1.62	УЭТХ /СОЭ/	10104005	4,500
1.63	Цусны ABO, резус бүлэг тодорхойлох	10105044	11,000
Шээсний ерөнхий, шимэгч хорхой илрүүлэх шинжилгээ			
1.64	Шээсний ерөнхий шинжилгээ	10113019	6,000
1.65	Шимэгч хорхойн өндөг илрүүлэг /натив харах/	10110013	5,000
1.66	Шээсэнд цөсний пигмент тодорхойлох	19901001	5,000
Молекул биологи			
1.67	Элэгний В вирусийн ДНХ тоолох (HBV-DNA)	10108031	133,000
1.68	Элэгний С вирусийн PHX тоолох (HCV-RNA)	10108035	139,000
1.69	Ковид-19 (Covid-19/SARS CoV-2) халдвар PHX илрүүлэх	10108007	35,000
1.70	RT-PCR үндсэн 7 үүсгэгч (Trichomonas vaginalis, Mycoplasma hominis, Mycoplasma genitalium, Chlamydia trachomatis, Neisseria gonorrhoeae, Ureaplasma parvum, Ureaplasma urealyticum)	10106073	165,000
1.71	RT-PCR шархлаат халдварын 7 үүсгэгч (Herpes simplex virus type 1, Herpes simplex virus type 2, Cytomegalovirus, Varisella-zoster virus, Lymphogranuloma venereum, Treponema pallidum, Haemophilus ducrey)	10106076	140,000



Нян судлал			
1.72	Бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ (шарх, хамар, хамар залгиур, чих, нүд, умайн хүзүү, шээсний сүв, үтрээ, өтгөн, идээ, буглаа, цэр, шээс, гуурсны арчдас/трахеостом, интубац, хэвлий, цээж, давсаг, ЭДВ-н болон бусад гуурс), хатгалтын шингэн, цэр бронхийн угаадасны нян судлалын шинжилгээ /хэвлий, плевр, тархи нугасны шингэн, үений шингэн, олгой цөс/	10101003	32,000
1.73	Хүчилд тэсвэртэй нян илрүүлэх түрхэцийн шинжилгээ	10101007	15,000
1.74	Үтрээний арчдасын шинжилгээ	10113014	13,000
1.75	Мөөгөнцөр илрүүлэх	10101002	28,000
1.76	Микобактери илрүүлэх болон РИФ тэсвэржилт тодорхойлох	10101001	35,000
Цитологи			
1.77	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх /зөөлөн эд, бүх төрлийн дурангаар авсан эд/	20303001	40,000
1.78	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх /ясны эд/	20303002	66,000
1.79	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх	20303003	106,000
1.80	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх /мэс ажилбараас авсан эд/	20303001	79,000
2. НҮДНИЙ ЭМГЭГИЙН ОНОШЛОГООНЫ АЖИЛБАР, ХЭМЖИЛТ, СОРИЛ, ШИНЖИЛГЭЭ			
2.1	Нулимсны замын шинжилгээ	10213001	30,000
2.2	Нүдний эмгэгийн багажийн оношлогоо	10213002	30,000
2.3	Нүдний өнцөг нээх лазер/YAG/ 1 нүдний /	10223004	80,000
2.4	Нүдний өнцөг нээх лазер/YAG//2 нүдний/	10223004	150,000
3. ЧИХ ХАМАР ХООЛОЙ			
3.1	Гүйлс орчмын буглаа	19901001	100,000
3.2	Таславчийн буглаа нээх	19901001	100,000
3.3	Хамар, чихний хатиг буглаа нээх	19901001	35,000
3.4	Чих цэвэрлэх	19901001	5,000
3.5	Хамар чихнээс гадны биет авах	19901001	35,000
3.6	Хоолойд эм түрхэх	19901001	35,000
3.7	Хатуу дуран /хамар, чих, төвөнх/	10202004	30,000
3.8	Аудиотетрийн шинжилгээ	10225002	22,000
3.9	Хамрын ясны хугарал засах	19901001	150,000
3.10	Хамрын цус алдалт коагуляци хийж тогтоох	19901001	30,000
3.11	Хамрын цус алдалтын өмнөд чихээс хийж тогтоох	19901001	25,000
4. ДҮРС ОНОШЛОГОО			
4.1	Рентген зурагны хариу бичих	10214002	10,000
4.2	Рентген харалт дижитал	10214006	10,000
4.3	Рентген зураг авалт	10214003	20,000
4.4	Хоол боловсруулах замын баритай шинжилгээ /Улаан хоолой, ходоод, дээд гэдэс/	10214008	60,000
4.5	Хэвлийн цуллаг эрхтний хэт авиан шинжилгээ	10203002	15,000
4.6	Умайн, умайн дайвар, хөх түрүү булчирхай, бамбай булчирхайн хэт авиан оношлогоо	10203002	15,000

4.7	Ургийн хэт авиан оношлогоо	19901001	40,000
5. САЙН ДУРЫН ДАРХЛААЖУУЛАЛТ			
5.1	Галзуугийн эсрэг дархлаажуулалт	11001005	10,000
5.2	Хепатит В вирусын эсрэг дархлаажуулалт	11001015	10,000
5.3	Томуугийн эсрэг дархлаажуулалт	11001010	10,000
5.4	Товлолын дархлаажуулалтын багц /дуудлагаар/	19901001	50,000
6. ШҮДНИЙ ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭ			
6.1	Шүдний өнгөц цоорлын эмчилгээ /1 шүд/	19901001	25,000
6.2	Шүдний дунд цоорлын эмчилгээ /1 шүд/	19901001	30,000
6.3	Шүдний гүн цоорлын эмчилгээ /1 шүд/	19901001	35,000
6.4	Нэг сувагтай шүдний сувгийн эмчилгээ /1шүд/	19901001	60,000
6.5	Хоёр сувагтай шүдний сувгийн эмчилгээ /1 шүд/	19901001	70,000
6.6	Гурван сувагтай шүдний сувгийн эмчилгээ /1 шүд/	19901001	80,000
6.7	Шүдний чулуу цэвэрлэх /1 шүд/	19901001	2,000
6.8	Шүдний хатуу эдэд лак гель түрхэх / Фтор,1 шүд/	19901001	20,000
6.9	Байнгын шүд авах /1 шүд/	19901001	20,000
6.10	Сүүн шүд авах /1 шүд/	19901001	10,000
6.11	Голонцортой шүд хийх	10401006	40,000
7. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОНОШЛОГОО, ЭМЧИЛГЭЭ			
7.1	Жирэмслэхээс сэргийлэх суулгац тавих	19901001	50,000
7.2	Жирэмслэхээс сэргийлэх суулгац авах	19901001	20,000
7.3	Ургийн зүрхний цахилгаан бичлэг	10201009	30,000
7.4	Цитологийн шинжилгээ	10112004	10,000
8. МЭС ЗАСЛЫН ЭМЧИЛГЭЭ			
8.1	Арьсны хоргүй хавдар үү, ургацаг цахилгаанаар түлж авах	11201002	40,000
8.2	Төмсөгний ус авах	1991001	20,000
8.3	Хатаах тариа шамбарамд хийх /тариа нь орох/	1991001	85,000
8.4	Хэвлий, цээжний хөндийн хатгалт	1991001	20,000
8.5	Хэвлийн хөндийд шингэн хурах үед хэвлийн хөндийн хатгалт хийж, шингэн авах	1991001	20,000
8.6	Идээт артром авах	1991001	20,000
8.7	Сэтэрхий чих оёх	11201022	45,000
8.8	Өөхөн хавдар авах 5см хүртэл	1991001	18,000
8.9	Сорви засах	1991001	25,000
8.10	Давсагт шээсний катетр тавих	1991001	10,000
8.11	Гадны биет авах	1991001	20,000
8.12	Өвдөгний үенд тариа хийх / тариа нь орохгүй/	1991001	40,000
8.13	Архины эсрэг суулгац тавих/ суулгац орохгүй/	1991001	50,000
8.14	Бартолонет нээх	1991001	30,000
8.15	Шигдсэн хумс авах	1991001	30,000
8.16	Үений гематома соруулах	1991001	15,000
9. УЛАМЖЛАЛТ, СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭ			
9.1	Зүү эмчилгээ	1991001	15,000
9.2	Чихний зүү	1991001	5,000
9.3	Төөнө засал	1991001	5,000
9.4	Хэсэг газрын иллэг массаж	1991001	10,000
9.5	Бүтэн биеийн бариа	1991001	35,000
9.6	Бумба	1991001	5,000

9.7	Гулгуур бумба	1991001	10,000
9.8	Самнуур, шивүүр	1991001	15,000
9.9	Хануур засал	1991001	25,000
9.10	Доргиох массаж	1991001	5,000
9.11	УВЧ	1991001	3,000
9.12	Электрофорез	1991001	3,000
9.13	Инфра /Соллюкс/	1991001	3,000
9.14	Лазер	1991001	8,000
9.15	Искра	1991001	3,000
9.16	Ультразвук	1991001	3,000
9.17	Гуурст кварц	1991001	2,000
9.18	Татлага /хүзүүний/	1991001	5,000
9.19	Татлага /нурууны/	1991001	5,000
9.20	ICT /Tens/	1991001	5,000
9.21	Утлага	1991001	2,000
9.22	Аэромассаж	1991001	5,000
10. БАГАЖИЙН ОНОШЛОГОО			
10.1	12 сувгийн холтер зүрхний цахилгаан бичлэг	10201001	80,000
10.2	Зүрхний цахилгаан бичлэг	10201005	9,000
10.3	Зүрхний ЭХО оношлогоо	10203002	50,000
10.4	Тархины цахилгаан бичлэг	10218002	40,000
10.5	Ходоодны уян дуран /унтуулгагүй/	10202003	70,000
10.6	Ходоодны дурангийн биопси	19901001	200,000
10.7	Бүдүүн гэдэсний дуран /унтуулгагүй/	19901001	70,000
11. СТРЕССИЙН ШАЛТГААНТ МЭДРЭЛИЙН ЯДАРГАА, НОЙРГҮЙДЭЛ ЗЭРЭГ ЭМГЭГИЙН ОНОШЛОГОО, ЭМЧИЛГЭЭ			
11.1	Ганцаарчилсан сэтгэлзүйн зөвлөгөө /60 минут/	19901001	20,000
11.2	Ганцаарчилсан сэтгэлзүйн зөвлөгөө /90 минут/	19901001	30,000
12. СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ			
12.1	Дуслаар тарилга хийх	19901001	15,000
12.2	Судсаар тарилга хийх	19901001	10,000
12.3	Булчинд тарилга хийх	19901001	5,000
12.4	Арьсан дор тарилга хийх	19901001	5,000
12.5	Гэрийн сувилахуйн тусламж үйлчилгээний багц (тариа тарилга, мэс заслын боолт, асаргаа сувилгаа, сорьц цуглуулах, зөвлөгөө гэх мэт)	19901001	50,000
13. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ ҮЗЛЭГ, ЗӨВЛӨГӨӨ			
13.1	Жолооны үнэмлэх авах эрүүл мэндийн үзлэг	11101005	30,000
13.2	Шинээр гэр бүл бологсдын эрүүл мэндийн үзлэг	11101004	80,000
13.3	Буу галт зэвсэг эзэмших сэтгэцийн эрүүл мэндийн үзлэг	11101002	20,000
13.4	Гадаад ажилтныг Монгол улсад ирсний дараа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ /Эрүүл мэндийн сайд, хөдөлмөр нийгмийн хамгаалалын сайдын хамтарсан 2023 оны 12 сарын 28-ны А/483, А/220/ тушаал/	11101003	100,000
13.5	Гадаад явахад шаардлагатай эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ	11101003	80,000



9023110401 905658 НД2335

13.6	Ажил сургуульд орох зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоо шинжилгээнд хамрагдах эрүүл мэндийн хуудас /Элэгний үйл ажиллагаа, ЦЕШ, ШЕШ, ДОХ, серологи, HBsAd, HCV/	11101004	80,000
13.7	Ажил сургуульд орох эрүүл мэндийн хуудас /ДОХ, серологи/	11101004	50,000
13.8	Эрүүл мэндийн ажилтны үзлэг шинжилгээ	11101004	60,000
13.9	Зусланд амрах хүүхдийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ	19901001	10,000
13.10	Эрүүл зүйн шинжилгээ /1 хүний/	11101001	50,000
13.11	Аж ахуйн нэгж байгууллагын захиалгаар зохион байгуулсан багцын урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	11101001	Гэрээний дүнгээр
13.12	Усан бассейнд явах эрүүл мэндийн хуудас	0-18	10,000
		18-аас дээш	20,000
13.13	Цэцэрлэгийн хүүхдийн шинжилгээ /Шимэгч хорхойн өндөг илрүүлэг, Шээсэнд цөсний пегмент тодорхойлох/	11101001	10,000
13.14	Дархлаажуулалтын гэрчилгээ	11101001	10,000
14. НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ			
14.1	Эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээ/ 1 хоног, энгийн/	31401005	15,000
14.2	Эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээ/1 хоног, хагас люкс/	31401005	20,000
14.3	Бикс ариутгах /том, дунд/	31404001	20,000
14.4	Бикс ариутгах /жижиг/	31404001	15,000
14.5	Захиалгаар өвчтөн тээвэрлэх 1 км-т яаралтай болон түргэн тусламжаас бусад тохиолдолд	31406001	2,000
14.6	Донтолт, архидалт, мансуурлаас үүссэн гэмтэл, хордлогын оношлогоо эмчилгээ /Амбулаторийн үзлэг, оношлогоо/	19901001	50,000
14.7	Иргэн санаатайгаар амь насаа өгүүтгэхээр оролдсон тохиолдлын эмнэлгийн тусламж үйлчилгээ /Амбулаторийн үзлэг, оношлогоо/	19901001	50,000
14.8	Өөрийн болон бусдын буруутайгаас үүдсэн осол бэртэл гэмтэл, зодоон цохионы үед үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ /Амбулаторийн үзлэг, оношлогоо/	19901001	50,000
14.9	Ажлын бус цагаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ		Тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бодит зардлаар
14.10	Эрүүл мэндийн байгууллага нь үндсэн үйл ажиллагаагаа алдагдуулахгүйгээр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэхийн тусламж үйлчилгээг тухайн байгууллагын байршилд очиж үзүүлэх		Тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бодит зардлаар